

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

### ЭКО ТӨЛБӨРИЙН ТУХАЙ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь байгаль орчинд халтай бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импорт, хэрэглээг бууруулж, үүсэх хог хаягдлыг багасгах зорилгоор зарим бараа, бүтээгдэхүүнд эко төлбөр ногдуулах, төлбөрийн орлогыг төсөвт төвлөрүүлэх, зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Эко төлбөрийн тухай хууль тогтоомж

2.1.Эко төлбөрийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Байгаль орчныг хамгаалах тухай хууль<sup>2</sup>, Хог хаягдлын тухай хууль<sup>3</sup>, Татварын ерөнхий хууль<sup>4</sup>, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

#### 3 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1.“ахуйн хэрэглээний зай хураагуур” гэж ахуйн хэрэглээний цэнэглэдэг болон цэнэглэдэггүй бүх төрлийн зай хураагуурыг;

3.1.2.“аккумулятор, бусад зай хураагуур” гэж тээврийн хэрэгсэлд болон үйлдвэрлэлд эрчим хүчний тэжээлийн эх үүсвэр, нөөцлүүрийн зориулалтаар ашиглагдах бүх төрлийн зай хураагуурыг;

3.1.3.“импортлогч” гэж Монгол Улсын хилээр энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүнийг импортоор оруулж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.4.“үйлдвэрлэгч” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүнийг ашиглан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа хувь хүн, хуулийн этгээдийг;

3.1.5.“эко төлбөр” гэж байгаль орчинд халтай бараа, бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, үүсэх хог хаягдлыг багасгах зорилгоор зарим бараа, бүтээгдэхүүнд ногдуулах төлбөрийг;

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэнхууль-“Төрийнмэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Байгаль орчныг хамгаалах тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Хог хаягдлын тухай хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Татварын ерөнхий хууль-“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

3.1.6. “хоол хүнсний нэг удаагийн хуванцар хэрэгсэл” гэж хоол хүнсний зориулалттай, нийлэг материалаар хийсэн, нэг удаагийн сав, аяга, таваг, халбага, хутга, сэрээ, хутгуур, соруулыг;

3.1.7. “нийлэг материал” гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.53-т заасныг;

3.1.8. “хуванцар сав” гэж бүх төрлийн бүтээгдэхүүний полиэтилен, полипропилен, полистирол, поливинилхлорид, бисфенол А болон бусад төрлийн нийлэг материалаар хийсэн савыг.

#### **4 дүгээр зүйл. Эко төлбөр төлөгч, түүний бүртгэл**

4.1. Энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, импортлогч хувь хүн, хуулийн этгээд эко төлбөр төлөгч байна.

4.2. Эко төлбөр төлөгч нь харьяалах татварын албанд бүртгэлтэй байна.

4.3. Эко төлбөр төлөгчийн бүртгэлд нэр, хаяг, байршил, хувь хүн, хуулийн этгээдийн регистрийн дугаар, төлбөр ногдох зүйлийн талаарх мэдээллийг тусгана.

#### **5 дугаар зүйл. Эко төлбөр ногдох зүйл**

5.1. Эко төлбөр төлөгчийн үйлдвэрлэсэн, импортолсон дараах төрлийн бараа, бүтээгдэхүүнд эко төлбөр /цаашид “төлбөр” гэх/ ногдуулна:

5.1.1. хоол хүнсний нэг удаагийн хуванцар хэрэгсэл;

5.1.2. нийлэг хальсан уут;

5.1.3. бүх төрлийн бүтээгдэхүүний хуванцар сав болон бүтээгдэхүүн савлахад зориулж үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн хоосон хуванцар сав;

5.1.4. бүх төрлийн тээврийн хэрэгслийн шинэ, хуучин дугуй;

5.1.5. ахуйн хэрэглээний зай хураагуур;

5.1.6. аккумулятор, бусад зай хураагуур;

5.1.7. химийн бодис;

5.1.8. бүх төрлийн бүтээгдэхүүний шилэн лонх, сав болон бүтээгдэхүүн савлахад зориулж үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн хоосон шилэн лонх, сав;

5.1.9. цахилгаан хэрэгсэл.

5.2. Төлбөрийг энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүнд давхардуулан ногдуулахгүй.

5.3. Төлбөр ногдуулах энэ хуулийн 5.1.2, 5.1.6, 5.1.7, 5.1.9-д заасан бараа, бүтээгдэхүүн, химийн бодисын жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

*Тайлбар. Энэ зүйлийн 5.1.4, 5.1.6 дахь заалт дангаар болон импортолсон бүх төрлийн дээврийн хэрэгслийн дугуй, аккумуляторт хамаарна.*

#### **6 дугаар зүйл. Эко төлбөр ногдуулах биет нэгж**

6.1.Төлбөрийг дараах биет нэгжээр тооцож ногдуулна:

6.1.1.хоол хүнсний нэг удаагийн хуванцар хэрэгслийг килограммаар;

6.1.2.нийлэг хальсан уутыг килограммаар;

6.1.3.бүх төрлийн бүтээгдэхүүний хуванцар сав болон бүтээгдэхүүн савлахад зориулж үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн хоосон хуванцар савыг килограммаар;

6.1.4.бүх төрлийн тээврийн хэрэгслийн дугуйг ширхгээр;

6.1.5.ахуйн хэрэглээний зай хураагуурыг ширхгээр;

6.1.6.аккумулятор, бусад зай хураагуурыг ширхгээр;

6.1.7.химийн бодисыг килограмаар;

6.1.8.бүх төрлийн бүтээгдэхүүний шилэн лонх, сав болон бүтээгдэхүүн савлахад зориулж үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн хоосон шилэн лонх, савыг килограммаар;

6.1.9.цахилгаан хэрэгслийг ширхгээр.

**7 дугаар зүйл.Эко төлбөрийн хэмжээ, түүнийг төвлөрүүлэх, зарцуулах**

7.1.Энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүний тогтоосон биет нэгжид дараах хэмжээгээр төлбөр ногдуулна:

Д/д	Төлбөр ногдох зүйл, биет нэгж	Ногдуулах төлбөрийн хэмжээ	
1	Хоол хүнсний нэг удаагийн хуванцар хэрэгсэл, килограмм тутамд	Үнийн дүнгийн 4 хувь	
2	Нийлэг хальсан уут, килограмм тутамд	Үйлдвэрлэсэн	Үнийн дүнгийн 10 хувь
		Импортолсон	Үнийн дүнгийн 40 хувь
3	Бүтээгдэхүүний хуванцар сав болон бүтээгдэхүүн савлахад зориулж үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн хоосон хуванцар сав, килограмм тутамд	Үнийн дүнгийн 10 хувь	
4	Бүх төрлийн тээврийн хэрэгслийн дугуй, ширхэг тутамд	Шинэ	Үнийн дүнгийн 0.3 хувь
		Хуучин	Үнийн дүнгийн 10 хувь
5	Ахуйн хэрэглээний зай хураагуур, ширхэг тутамд	Үнийн дүнгийн 15 хувь	
6	Аккумулятор, бусад зай хураагуур, ширхэг тутамд	Үнийн дүнгийн 10 хувь	
7	Химийн бодис, килограмм тутамд	Үнийн дүнгийн 3 хувь	
8	Бүх төрлийн бүтээгдэхүүний шилэн лонх, сав болон бүтээгдэхүүн савлахад зориулж үйлдвэрлэсэн, импортолсон бүх төрлийн хоосон шилэн лонх, сав, килограмм тутамд	Үнийн дүнгийн 15 хувь	
9	Цахилгаан хэрэгсэл, ширхэг тутамд	Үнийн дүнгийн 1 хувь	

7.2.Импортолсон бүтээгдэхүүний хуванцар сав болон шилэн лонх, савны үнийн дүнг доор дурдсанаар тодорхойлно:

7.2.1.хуванцар савны үнийн дүнг биет нэгж буюу тухайн савны өөрийн жинтэй дүйцэх хэмжээтэй импортолсон хуванцар савны бэлдцийн гаалийн үнээр;

7.2.2.шилэн лонх, савны үнийн дүнг импортолсон ижил төрлийн хоосон шилэн лонх, савны гаалийн үнээр.

7.3.Үйлдвэрлэсэн эко төлбөр ногдох бараа, бүтээгдэхүүний үнийн дүнг тухайн бараа, бүтээгдэхүүний үйлдвэрийн үнээр тодорхойлно.

7.4.Төлбөрийн орлогыг Байгаль орчин, уур амьсгалын санд төвлөрүүлэн хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэхэд зарцуулах бөгөөд орлогын 50-иас доошгүй хувийг дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг цуглуулах, ангилан ялгах, тээвэрлэх, дахин боловсруулах арга хэмжээнд зарцуулна.

7.5.Төлбөрийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг Засгийн газар батална.

## **8 дугаар зүйл.Эко төлбөр төлөх, тайлагнах**

8.1.Төлбөр төлөгч-үйлдвэрлэгч нь тухайн жилд үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнд ногдох төлбөрийг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор харьяалах татварын албанд төлнө.

8.2.Төлбөр төлөгч-импортлогч нь энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүнд ногдох төлбөрийг тухайн бараа, бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр оруулж ирсэн тухай бүрт Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд заасан журмын дагуу төлнө.

8.3.Татварын алба төлбөрийн жилийн тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

8.3.1.сум, дүүргийн татварын тасаг, хэлтэс төлбөрийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор аймаг, нийслэлийн татварын газарт;

8.3.2.аймаг, нийслэлийн татварын газар төлбөрийн жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад;

8.3.3.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

8.4.Гаалийн байгууллага төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

8.5.Үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүнд ногдох төлбөрийн тайлангийн маягтыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, импортолсон бараа, бүтээгдэхүүнд ногдох төлбөрийн тайлангийн маягтыг гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

## **9 дүгээр зүйл.Эко төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх**

9.1.Энэ хуулийн 5.1.7-д зааснаас бусад төлбөр ногдох бараа, бүтээгдэхүүнээс үүссэн хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 40.5-д заасны дагуу дахин боловсруулсан, сэргээн ашигласан, дахин ашигласан тоо, хэмжээгээр үйлдвэрлэгч, импортлогчийг төлбөрөөс хөнгөлнө.

9.2.Дараах зориулалтаар импортолсон энэ хуулийн 5.1-д заасан бараа, бүтээгдэхүүнийг төлбөрөөс чөлөөлнө:

9.2.1.зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл;

9.2.2.хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламжийн бараа;

9.2.3.зөвхөн тахир дутуу тэргэнцэртэй хүнийг суулгах, буулгах зам, тавцан, өргүүртэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн өөрөө жолоодох, удирдлага нь зөвхөн гар ажиллагаатай, дээрхийн адил бүрэн тоноглогдон үйлдвэрлэгдсэн, тусгай зориулалтын автомашин;

9.2.4.гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүний төрөлжсөн салбарын албан хэрэгцээнд зориулан импортлосон бараа, бүтээгдэхүүн;

9.2.5.гадаадын дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн, дипломат ажилтан, үйлчилгээ, техникийн ажилтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн суух улсдаа шилжин суурьшихад шаардагдах хувийн хэрэглээний эд зүйл.

9.3.Төлбөрөөс хөнгөлөх журам, хөнгөлөлтийн хувь хэмжээг Засгийн газар батална.

## **10 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

10.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

10.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

ГАРЫН ҮСЭГ